

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Аялгуу соёлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/017/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн
Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.10 № 34
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН АЯЛГУУ
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Н.БАТ-УНДРАХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Аялгуу соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон аймгийн Аялгуу соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Түлээ нүүрсний хөнгөлөлтөөс татвар суутгаагүй, ур чадварын нэмэгдлийг илүү тооцоолсон болон нягтлан бодогч нь өөртөө илүү цалин бодсон, татварын хөнгөлөлт давхардуулан эдлүүлж нийт 4,932.1 мянган төгрөгийн цалин, тэтгэмжийг илүү бодож олгосон,
2. Тайлант онд хувь хүний орлогын албан татварын 1,352.3 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн,
3. Орон нутгийн төсвөөс албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд олгосон санхүүжилтийн хэмнэлт 1,477.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлээгүй зэрэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн

612505193

D:\my doc \alban bichig\2025-A4.doc

холбогдох заалт, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Аялгуу соёлын төв нь 2025 оны санхүүгийн тайлангийн хугацаанд улсын төсвөөс 366,447.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой 21,788.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зардлын зүйл ангиар зарцуулж, хэмнэлтийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд эд хогшил, урсгал засварын зардлаас 117,190.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авч, урлагийн заал, тоног төхөөрөмжийн түрээсийн болон тоглолтын орлогоор 21,287.0 мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлого олж санхүүгийн тайланд тусгасан байна.

Хийн халаалтын системд 17-р сургуулийг шилжүүлсэнтэй холбоотойгоор тухайн байршлын төсвийн байгууллагуудыг уг хийх халаалттай холбосон тул тайланд онд Аялгуу соёлын төв нь түлш, халаалтын зардлын 9,700.0 мянган төгрөгийн төсвийг бүрэн хэмнэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийг төлөвлөгөөг 10 зорилт 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 93.0 хувьтай үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний

баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

	/төгрөгөөр/	
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>12,568,800.00</u>	<u>20,343,435.28</u>
АВЛАГА	0.00	809,935.28
Татаас, санхүүжилтийн авлага		809,935.28
БАРАА МАТЕРИАЛ	12,568,800.00	19,533,500.00
Түүхий эд материал	12,568,800.00	17,963,500.00
Тусгай зориулалттай материал	12,568,800.00	17,963,500.00
Хангамжийн материал	0.00	1,570,000.00
Аж ахуйн материал	0.00	1,570,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,502,971,881.88</u>	<u>1,477,507,686.53</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,502,971,881.88	1,477,507,686.53
Биет хөрөнгө	1,453,683,548.68	1,427,712,202.53
Барилга, байгууламж, орон сууц	1,448,995,560.00	1,448,995,560.00
Хуримтлагдсан элэгдэл	-193,932,304.80	-242,415,381.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	187,205,600.00	285,986,480.00
Хуримтлагдсан элэгдэл	-64,444,532.92	-136,247,843.23
Тавилга, аж ахуйн эд хогшил	82,803,396.00	100,293,396.00
Хуримтлагдсан элэгдэл	-9,995,409.60	-31,951,249.24
Ном	3,051,240.00	3,051,240.00
Биет бус хөрөнгө	49,288,333.20	49,795,484.00
Програм хангамж	1,250,000.00	2,169,908.00
Хуримтлагдсан элэгдэл	-1,041,666.80	-1,454,424.00
Бусад биет бус хөрөнгө	49,080,000.00	49,080,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,515,540,681.88</u>	<u>1,497,851,121.81</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>373,684.00</u>	<u>1,352,259.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	373,684.00	1,352,259.00
Өглөг	373,684.00	1,352,259.00
Ажилчидтай холбогдсон өглөг	373,684.00	1,352,259.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,515,166,997.88</u>	<u>1,495,688,927.53</u>
Засгийн газрын хувь оролцоо	1,515,166,997.88	1,495,688,927.53
Хуримтлагдсан үр дүн	1,515,166,997.88	1,495,688,927.53
Өмнөх үеийн үр дүн	1,515,166,997.88	1,515,166,997.88
Тайлант үеийн үр дүн	0.00	-18,668,135.07
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,515,540,681.88</u>	<u>1,497,851,121.81</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	414,050,477.92	438,909,614.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,487,901.00	50,674,214.00
Нийтлэг татварын бус орлого	101,487,901.00	50,674,214.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	31,139,901.00	50,674,214.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,139,901.00	50,674,214.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	70,348,000.00	0.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	312,562,576.92	388,235,400.00
Улсын төвлөрсөн төсвөөс	280,774,576.92	366,447,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	280,774,576.92	366,447,400.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,788,000.00	21,788,000.00
Орон нутгийн төсвийн санхүүжилт	31,788,000.00	21,788,000.00

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	396,999,551.39	457,577,749.07
УРСГАЛ ЗАРДАЛ	396,999,551.39	457,577,749.07
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	328,910,550.02	438,558,556.90
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,472,437.52	236,832,727.00
Цалин	103,093,808.42	126,210,680.00
Цалингийн тусгай нэмэгдлүүд	62,378,629.10	110,622,047.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,403,351.50	29,837,199.72
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	17,918,479.28	25,546,099.72
Эрүүл мэндийн даатгал	3,484,872.22	4,291,100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,452,632.06	5,246,686.83
Гэрэл, цахилгаан	2,444,158.06	2,991,665.25
Цэвэр, бохир ус	2,008,474.00	2,255,021.58
Хангамж, бараа материалын зардал	8,787,300.00	2,707,710.00
Бичиг хэрэг	1,427,750.00	1,096,600.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	713,850.00	765,010.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,742,700.00	846,100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	17,254,900.00	5,796,000.00
Урсгал засвар	17,254,900.00	5,796,000.00
Томилолт, зочны зардал	193,200.00	376,200.00
Дотоод албан томилолт	193,200.00	376,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,854,200.00	5,893,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,615,300.00	5,893,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	96,987,528.94	151,869,033.35
Бараа үйлчилгээний бусад зардал	66,000.00	214,050.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	9,000,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	96,921,528.94	142,654,983.35
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,089,001.37	19,019,192.17
Бусад урсгал шилжүүлэг	1,913,600.00	2,166,400.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	913,600.00	577,400.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,589,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,340,033.43	1,811,479.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	50,340,033.43	1,811,479.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,835,367.94	15,041,313.17
Төвлөрүүлэх шилжүүлэг	15,835,367.94	15,041,313.17
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>17,050,926.53</u>	<u>-18,668,135.07</u>
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>17,050,926.53</u>	<u>-18,668,135.07</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>343,702,477.92</u>	<u>438,909,614.00</u>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,139,901.00	50,674,214.00
Нийтлэг татварын бус орлого	31,139,901.00	50,674,214.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	31,139,901.00	50,674,214.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,139,901.00	50,674,214.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	312,562,576.92	388,235,400.00
Улсын төвлөрсөн төсвөөс	280,774,576.92	366,447,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	280,774,576.92	366,447,400.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,788,000.00	21,788,000.00
Орон нутгийн төсвийн санхүүжилт	31,788,000.00	21,788,000.00

/төгрөгөөр/

НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>302,612,841.45</u>	<u>321,718,826.00</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	302,612,841.45	321,718,826.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	234,073,840.08	301,889,698.55
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,813,197.13	235,854,152.00
Цалин	103,093,808.02	125,232,105.00
Цалингийн тусгай нэмэгдлүүд	61,719,389.11	110,622,047.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,765,910.89	29,837,199.72
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	18,395,912.28	25,546,099.72
Эрүүл мэндийн даатгал	3,369,998.61	4,291,100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,452,632.06	5,246,686.83
Гэрэл, цахилгаан	2,444,158.06	2,811,983.74
Цэвэр, бохир ус	2,008,474.00	2,434,703.09
Хангамж, бараа материалын зардал	3,566,750.00	6,298,910.00
Бичиг хэрэг	633,750.00	969,600.00
Тээвэр, шатахуун	1,783,000.00	0.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	713,850.00	765,010.00
Ном, хэвлэл	50,000.00	0.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	0.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	266,150.00	4,564,300.00
Нормативт зардал	499,950.00	75,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	499,950.00	75,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	17,914,900.00	7,561,700.00
Багаж, техник, хэрэгсэл	660,000.00	559,700.00
Тавилга	0.00	1,400,000.00
Урсгал засвар	17,254,900.00	5,602,000.00
Томилолт, зочны зардал	193,200.00	376,200.00
Дотоод албан томилолт	193,200.00	376,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,624,200.00	5,893,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,445,300.00	5,893,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,178,900.00	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,243,100.00	10,746,850.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,243,100.00	1,746,850.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	9,000,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,539,001.37	19,829,127.45
Бусад урсгал шилжүүлэг	2,363,600.00	2,166,400.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	913,600.00	577,400.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00	1,589,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,340,033.43	2,621,414.28
Төвлөрүүлэх шилжүүлэг	50,340,033.43	2,621,414.28
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,835,367.94	15,041,313.17
Төвлөрүүлэх шилжүүлэг	15,835,367.94	15,041,313.17
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>41,089,636.47</u>	<u>117,190,788.00</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,389,840.00	117,190,788.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,389,840.00	117,190,788.00
Дотоод эх үүсвэрээр	49,389,840.00	117,190,788.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,389,840.00	117,190,788.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-49,389,840.00</u>	<u>117,190,788.00</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-8,300,203.53	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,300,203.53	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	1,498,116,071.35	1,498,116,071.35
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	1,498,116,071.35	1,498,116,071.35
Тайлант үеийн үр дүн	0.00	17,050,926.53	17,050,926.53
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	1,515,166,997.88	1,515,166,997.88
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	1,515,166,997.88	1,515,166,997.88
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	1,515,166,997.88	1,515,166,997.88
Тайлант үеийн үр дүн	0.00	-19,478,070.35	-19,478,070.35
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	1,495,688,927.53	1,495,688,927.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	460,775,400.00	414,500,199.72	46,275,200.28	89.96
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	460,775,400.00	363,825,985.72	96,949,414.28	78.96
Улсын төсвөөс санхүүжих	460,775,400.00	363,825,985.72	96,949,414.28	78.96
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	50,674,214.00	-50,674,214.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	50,674,214.00	-50,674,214.00	
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	460,775,400.00	414,500,199.72	46,275,200.28	89.96
УРСГАЛ ЗАРДАЛ	460,775,400.00	414,500,199.72	46,275,200.28	89.96
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,578,000.00	412,333,799.72	46,244,200.28	89.92
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,544,300.00	235,854,152.00	28,690,148.00	89.15
Цалин	152,961,900.00	125,232,105.00	27,729,795.00	81.87
Цалингийн тусгай нэмэгдлүүд	111,582,400.00	110,622,047.00	960,353.00	99.14
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,068,000.00	29,837,199.72	3,230,800.28	90.23
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	28,776,900.00	25,546,099.72	3,230,800.28	88.77
Эрүүл мэндийн даатгал	4,291,100.00	4,291,100.00	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	8,970,200.00	6,298,910.00	2,671,290.00	0.00
Бичиг хэрэг	2,020,000.00	969,600.00	1,050,400.00	0.00
Тээвэр, шатахуун	300,000.00	0.00	300,000.00	0.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	765,010.00	134,990.00	0.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,750,200.00	4,564,300.00	1,185,900.00	0.00
Нормативт зардал	1,200,000.00	75,000.00	1,125,000.00	6.25
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	75,000.00	1,125,000.00	6.25
Эд хогшил, урсгал засварын зардал	122,139,700.00	122,097,688.00	42,012.00	99.97
Багаж, техник, хэрэгсэл	98,339,700.00	99,105,688.00	-765,988.00	0.00
Тавилга	19,000,000.00	18,890,000.00	110,000.00	0.00
Урсгал засвар	4,800,000.00	4,102,000.00	698,000.00	85.46
Томилолт, зочны зардал	750,000.00	376,200.00	373,800.00	50.16
Дотоод албан томилолт	750,000.00	376,200.00	373,800.00	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,700,000.00	5,893,000.00	3,807,000.00	60.75

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,550,000.00	5,893,000.00	3,657,000.00	0.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	0.00	150,000.00	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	18,205,800.00	11,901,650.00	6,304,150.00	65.37
Бараа үйлчилгээний бусад зардал	9,205,800.00	2,901,650.00	6,304,150.00	31.52
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,197,400.00	2,166,400.00	31,000.00	98.59
Бусад урсгал шилжүүлэг	2,197,400.00	2,166,400.00	31,000.00	98.59
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	577,400.00	577,400.00	0.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,620,000.00	1,589,000.00	31,000.00	98.09
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	100.00
Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	8.50	8.50	0.00	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
Гүйцэтгэх ажилтан	6.50	6.50	0.00	100.00
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	0.00	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	8.50	8.50	0.00	100.00
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	7.00	7.00	0.00	100.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.50	1.50	0.00	100.00

2.6 Аудит хийсэн орон нутгийн дансны төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	21,788,000.00	6,746,686.83	15,041,313.17	31.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,788,000.00	6,746,686.83	15,041,313.17	31.0
Орон нутгийн төсвөөс	21,788,000.00	6,746,686.83	15,041,313.17	31.0
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	21,788,000.00	6,746,686.83	15,041,313.17	31.0
УРСГАЛ ЗАРДАЛ	21,788,000.00	6,746,686.83	15,041,313.17	31.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,788,000.00	6,746,686.83	15,041,313.17	31.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,288,000.00	5,246,686.83	15,041,313.17	25.9
Гэрэл, цахилгаан	5,142,900.00	2,811,983.74	2,330,916.26	54.7
Түлш, халаалт	9,700,000.00	0.00	9,700,000.00	0.0
Цэвэр, бохир ус	5,445,100.00	2,434,703.09	3,010,396.91	44.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 17,559.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс 17,559.3 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

- Тайлант онд улсын төсөвт болон орон нутагт төвлөрүүлсэн нийт 15,851.2 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тухайн төвлөсөн дансны төвлөрүүлэх шилжүүлэг дансны ангиллаар тайлагнаагүй, санхүүгийн үр дүнгийн тайланд 38.1 мянган төгрөгийн бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлийн зардлыг цалингийн зардлаар, мөнгөн гүйлгээний тайланд урсгал засварын 1,670.0 мянган төгрөгийг багаж, техник хэрэгслийн зардлаар тус тус алдаатай илэрхийлсэн байна.

Аудитаар нийт 8,800.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 4,932.1 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 1,477.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2,391.2 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Түлээ нүүрсний хөнгөлөлтөөс татвар суутгаагүй, ур чадварын нэмэгдлийг илүү тооцоолсон болон нягтлан бодогч нь өөртөө илүү цалин бодсон, татварын хөнгөлөлт давхардуулан эдлүүлснээр нийт 4,932.1 мянган төгрөгийн цалин, тэтгэмжийг илүү бодож олгосонд 3 төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Орон нутгийн төсвөөс албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд олгосон санхүүжилтийн хэмнэлт 1,477.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлээгүйд албан шаардлага өгөв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд хувь хүний орлогын албан татварын 1,352.3 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох өр төлбөрийг бүрэн хянаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын татварын жилийн эцсийн тайланд татварын хөнгөлөлтийг алдаатай мэдээлсэн, нэг ажилтны цалинг өөр ажилтны нэрээр давхар татварын тайлангийн мэдээнд илэрхийлсэн, НДШ-ийн тайланг мөн зарим саруудад нягтлан бодогч өөрийнхөө тухайн сард бодогдсон цалингаас зөрүүтэй илэрхийлсэн, Б.Нямжаргалын амралтын цалингийн 7-р сард ногдох 684.7 мянган төгрөгийг НДШ-ийн тайланд мэдүүлээгүй зэргээр татвар, НДШ-ийн тайланг алдаатай бэлтгэж илгээсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Татварын ерөнхий хуулийн 29.1-д "Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана. Татвар төлөгч дараах үүргийг хүлээнэ", 29.1.3-д "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2-д "Ажил олгогч дараах

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үүрэг хүлээнэ", 32.2.2-д "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татвар, НДШ-ийн тайланг тухайн сарын бодогдсон цалинтай тулгаж үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлж байх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд буюу зардлын бүлэг хооронд нийт 354.2 мянган төгрөг зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн сар, улирлын хуваарийг баримталж, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахгүй байх.

Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймгийн Аялгуу соёлын төв	1	17,559.3			1	17,559.3	1	17,559.3				
Дүн	1	17,559.3			1	17,559.3	1	17,559.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Аялгуу соёлын төв	1	179.4	1	179.4								
	1	81.8	1	81.8								
	1	4,670.9	1	4,670.9								
	1	1,477.0			1	1,477.6						
	1	1,352.3					1	1,352.3				
	1	684.7					1	684.7				
	1	354.2					1	354.2				
Дүн	7	8,800.9	3	4,932.1	1	1,477.6	3	2,391.2				